



БАЙГАЛЬ  
ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

KFW



ТУСГАЙ  
ХАМГААЛАЛТАЙ  
ГАЗАР

## ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-ЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮР АШИГТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



*Гүйцэтгэгч:* Байгаль хамгааллын судалгаа,  
хөгжлийн төв ТББ

Улаанбаатар хот 2022 он

## **ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-ЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮР АШИГТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

БОАЖЯ-ны захиалгаар ХБНГУ-ын Сэргээн босголт зээлийн (KFW) банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд “ТХГН-уудын менежментийн үр ашигт байдлын шалгуур үзүүлэлтэд мониторинг, үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний хүрээнд Байгаль хамгаалалын судалгаа хөгжлийн төв ТББ боловсруулав.

Гүйцэтгэсэн: Байгаль хамгаалалын судалгаа хөгжлийн төв ТББ

Байгаль орчны гавьяат ажилтан, доктор(Ph.D), профессор А.Намхай

Доктор (Ph.D), профессор Д.Энэбиш

Доктор (Ph.D), профессор Д.Даш

Докторант Г. Довчиндорж

Биофизикч магистр Т.Цэнд-Аюуш

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
НЭГ. ҮНДЭСЛЭЛ	5
ХОЁР. ИХ ГАЗРЫН ЧУЛУУН БЦГ-ЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
ГУРАВ. ОЛОН УЛСЫН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН СҮЛЖЭЭНД БҮРТГЭГДСЭН БАЙДАЛ	8
ДӨРӨВ. ХАМГААЛАХ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	9
ТАВ. ХАМГААЛАХ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН АЮУЛ, ДАРАМТЫН ҮНЭЛГЭЭ	11
ЗУРГАА. ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-ЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮР АШИГТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	12
6.1 Хууль эрх зүйн зохицуулалт түүний хэрэгжилт	15
6.2 Төлөвлөлт, төлөвлөгөө түүний хэрэгжилт	15
6.3 Нөөц боломж	16
6.4 Бодит үйл ажиллагаа	17
6.5 Үнэлгээ мониторинг	18
6.6 Үр ашиг	18
ДҮГНЭЛТ	19
САНАЛ ЗӨВЛӨМЖ	20
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	21

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БНГ	Байгалийн нөөц газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДГ	Дурсгалт газар
ДЦГ	Дархан цаазат газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
БОЯБХУАӨДЗ	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл
НИБ	Нутгийн иргэдийн байгууллага
ИГЧБЦГ	Их газрын чулууны байгалийн цогцолборт газар
МҮАБҮ	Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ
СВД	Convention on Biological Diversity
ИВА	Important bird area
IUCN	International Union for Conservation of Nature
GEF	Global Environment Facility
GIZ	Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit
МАВ	Man and Biodiversity
МЕТТ	Management effectiveness tracking tool
TNC	The Nature Conservancy
UNEP	United Nations Environment Programme
UNESCO	United Nations Educational, Scientific and Cultural Organisation
UNDP	United Nations Development Programme
USAID	United States Agency for International Development
WB	World Bank
WDPA	World Database on Protected Areas
WWF	World wildlife fund for Nature


## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Их газрын чулууны БЦГ-ын анхны менежментийн төлөвлөгөө (2015-2018)-г 2014 онд боловсруулж мөрдүүлсэн. Дараагийн менежментийн төлөвлөгөөг 2021-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж 2021 онд батлуулжээ.

Их газрын чулууны БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээг анх 2018 онд хийсэн. Энэ удаагийн үнэлгээгээр бид ИГЧБЦГ-г тулгарч буй дарамтыг хэрхэн бууруулсан байдал, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийг хэрэгжилт, байгаль орчны зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байдал, хяналт шалгалт, сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээ, аялал жуулчлал, гадаад харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг талуудын оролцоотойгоор хэрхэн хийсэн зорилгодоо хүрсэн байдал, хийгдээгүй ажлууд түүний учир шалтгааныг энэхүү үнэлгээгээр үнэлэн дараагийн менежментийн төлөвлөгөөнд хэрхэн тусгах, боломжит бодит үр дүн гархаар ажлуудаа шат дараалалттай төлөвлөхөд энэхүү үнэлгээний зорилго оршиж байна. Цаашлаад менежментийн хэрэгжилтийн явцад гарсан үр ашиг, ахиц дэвшлийг тухайн салбарын хөгжлийн бодлогод зайлшгүй тусгах хэрэгтэй.

**ХОЁР. ТХГН-ИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**Ерөнхий хүснэгт 1**

ТХГН-ийн нэр	ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР		
Ангилал, зэрэглэл	Үндэсний		Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны зэрэглэлийн алинд тохирох
	Улс	Орон нутаг	Ia <input type="checkbox"/>
	ДЦГ <input type="checkbox"/>	ОНХГ <input type="checkbox"/>	Ib <input type="checkbox"/>
	БЦГ <input checked="" type="checkbox"/>		II <input checked="" type="checkbox"/>
	БНГ <input type="checkbox"/>	Агнуурын бүс нутаг <input type="checkbox"/>	III <input type="checkbox"/>
	ДГ <input type="checkbox"/>		IV <input type="checkbox"/>
V <input type="checkbox"/>			
		VI <input type="checkbox"/>	
Дэлхийн ТХГН-ийн сүлжээний бүртгэлийн дугаар буюу WDPА code <a href="https://www.protectedplanet.net/">https://www.protectedplanet.net/</a>			
ТХГН-ийн байршил (Улс, Засаг захиргааны нэгж, эко бүс нутаг, солбицол)		Засаг захиргааны хувьд, Дундговь аймгийн Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт сумдын нутаг дэвсгэрт харьяалагдана. 	
Байгуулагдсан огноо, холбогдох газрын шийдвэр, дугаар		УИХ-ын 2003 оны 30 дугаар тогтоолоор Байгалийн нөөц газар болгон улсын тусгай хамгаалалтад авсан бөгөөд УИХ-ын 2012 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Байгалийн цогцолборт газар болгон ангиллыг дээшлүүлсэн	
ТХГН-ийн нийт хэмжээ (га-аар), Дотоод болон орчны бүс тогтоосон бол бүс тус бүрийн хэмжээ (га-аар)		Анх 35000 га газрыг БНГ ангилалд аваад дараа нь БЦГ болгон талбайг 175,906 га болгон өргөтгөсөн. Онцгой бүс 2, аялал жуулчлалын бүс 3, хязгаарлалтын бүс 1 байна. <ul style="list-style-type: none"> <li>• Онцгой бүс 8762.9 га 4.98%</li> <li>• Аялал жуулчлалын бүс 57482.5 га 32.94%</li> <li>• Хязгаарлалтын бүс 109660.6 га 62.34%</li> <li>• Орчны бүс 174330.6 га 100.00%</li> </ul>	
ТХГН-ийн менежментийг хариуцагч байгууллагын нэр, хаяг (Хамгаалалтын захиргаа, менежментийг хариуцагч ТББ г.м)		<ul style="list-style-type: none"> <li>- Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Дундговь аймаг, Мандалговь хот</li> <li>- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А-06 тоот тушаалаар хамгаалалтын захиргааг Дундговь аймгийн Сайнцагаан суманд байгуулсан.</li> </ul>	
Удирдах дээд байгууллага		БОАЖЯ-ны ТХБНУГ	
ТХГН-ийн менежментийг хариуцагч байгууллагын бүтэц, орон тоо (Байнгын болон түр)		БОАЖСайдын 2022 оны 10 сарын 20-ны өдрийн А-439 тушаалаар 13 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс орон тооны 4 байгаль хамгаалагч, дарга, ня-бо, 3 мэргэжилтэн, үйлчилгээний 4 ажилтан ажиллаж байна.	

	Тайлбар /мян.төг/	Орлого				
		2018	2019	2020	2021	2022
Төсөв (Сүүлийн 5 жилийн жилээр, төрөл, эх үүсвэр тус бүрээр, мян.төг)	Батлагдсан төсөв	97,115.1	126,241.2	191,412.0	168,973.3	185,312.7
	Зарлага	96,804.2	114,058.4	174,784.6	159,470.7	172,392.7
	Өөрийн орлого	562.2	870.2	1,343.0	365.2	892.5
Хамгаалалтад авсан үндэслэл	Эргэн тойрон тал хээрээр хүрээлэгдсэн Монголын их боржингийн бүсэд хамгийн их талбайг эзлэн оршдог Их газрын чулууны өвөрмөц тогтоц бүхий хээрийн бүс, ховор ургамал, амьтан тархсан Ерлөг, Гурвансайхан уул, түүх соёл, байгалийн өвөрмөц тогтоцууд нь тус газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл болсон. Энэ нутгийг хамгаалснаар тэнд явагдаж буй байгалийн үзэгдэл, өөрчлөлтийн үйл явцыг хам бүрдлүүдтэй нь цогц байдлаар судлан шинжилж, холбогдох хяналт, мониторингийн үнэлгээг системтэй явуулах боломж бүрдэж, байгалийн нөөц, баялаг, амьтан, ургамлын олон янз байдлын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, өсөлт, үржлийг нь хангах, Олон улсын гэрээ конвенциудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.					
ТХГН-ийн менежментийн үндсэн зорилго	Нутгийн иргэдийн идэвхитэй оролцоотойгоор байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгал, рашаан ус, газрын хэвлий, биологийн олон янз байдал хамгаалагдаж, төв халхын нүүдэлчин соёл хадгалагдаж, аялал жуулчлал хөгжсөнөөр иргэдийн амьжиргаа дээшилсэн байна.					
Зорилго 1	2018 он гэхэд аргаль хонины тоогтолгойг 100, янгирын тоог 30-д тус тус хүргэнэ.					
Зорилго 2	2018 он гэхэд байгалийн өвөрмөц тогтоц, түүх соёлын өвийн төлөв байдлыг 2015 оныхоос дордуулахгүй, хамгаалалт сайжирсан байна.					
Зорилго 3	Талхлагдсан талбайн эзлэх хувийг 15 хувь хүртэл буюу 2014 оны түвшинээс 50 хувиар бууруулна.					
Зорилго 4	2018 он гэхэд рашааны ундарга сэргэсэн байна. Мөн хэвийн ундаргатай булгийн тоо 3 болсон байна.					
<b>Үнэлгээнд оролцогчдын талаарх мэдээлэл</b>						
Үнэлгээг захиалан хийлгэсэн байгууллагын нэр, хаяг	БОАЖЯ, ТХНУГ Германы Сэргээн Босголтын Зээлийн Банкаар (KfW) дамжуулан Монгол улсад хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл					
Үнэлгээ хийсэн байгууллага, мэргэжлийн баг, шинжээч, зөвлөх, албан тушаал, хаяг, и-мэйл, утас	<b>Багийн ахлагч:</b> Байгаль орчны гавьяат ажилтан, доктор(Ph.D), профессор А.Намхай 99192168, <a href="mailto:namkhai_spa@yahoo.com">namkhai_spa@yahoo.com</a> <b>Багийн гишүүд:</b> Доктор (Ph.D), профессор Д.Энэбиш 99742613, <a href="mailto:d_eneed@yahoo.com">d_eneed@yahoo.com</a> Доктор (Ph.D), профессор Д.Даш Доктор (Ph.D), Г.Даваа Докторант Г. Довчиндорж 99035781, <a href="mailto:dovchoo_g10@yahoo.com">dovchoo_g10@yahoo.com</a> Биофизикч магистр Т.Цэнд-Аюуш					
Үнэлгээ хийсэн огноо	2018, 2022					
Үнэлгээнд оролцсон хүмүүсийн нэр, албан тушаал	Байгаль орчих аялал жуулчлалын газар, Цаг уур орчны шинжилгээний газар, сумдын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, малчдын төлөөлөл, ХЗ-ны дарга, ня бо, байгаль хамгаалагч					
Үнэлгээнд оролцсон хүмүүсийн харьяалал, тоо	ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажилтан	5				
	Нутгийн иргэн	6				
	Орон нутгийн засаг захиргааны төлөөлөл	4				
	Нутгийн иргэдийн байгууллага (ТББ, нөхөрлөл, малчны бүлэг гэх мэт)					
	Судлаач					
	Олон улсын ТББ					
	ААН-ийн төлөөлөл	3				
БҮГД	18					

ГУРАВ. ОЛОН УЛСЫН ХГН-ИЙН СҮЛЖЭЭНД БҮРТГЭГДСЭН БАЙДАЛ

Ерөнхий хүснэгт 2.

1. Дэлхийн Өв - UNESCO World Heritage <a href="http://whc.unesco.org/en/list/">http://whc.unesco.org/en/list/</a>									
Газрын нэр	<b>Бүртгэгдээгүй</b>								
Бүртгэгдсэн огноо									
Өвийн төрөл	Байгалийн өв <input type="checkbox"/>	Соёлын өв <input type="checkbox"/>	Байгаль, соёлын хосолсон өв <input type="checkbox"/>						
Талбайн хэмжээ (га)									
Газарзүйн солбицол									
Дэлхийн өвд бүртгэгдсэн үндэслэл									
Хамгаалалтын зорилгод нийцүүлж хэрэгжүүлсэн ажлууд (3-аас доошгүй үйл ажиллагааны үр дүнг бичих)									
2. Хүн ба Шим мандлын нөөц газар - Man and Biosphere / MAB <a href="http://www.unesco.org/new/en/natural-sciences/environment/ecological-sciences/biosphere-reserves/world-network-wnbr/wnbr/">http://www.unesco.org/new/en/natural-sciences/environment/ecological-sciences/biosphere-reserves/world-network-wnbr/wnbr/</a>									
Газрын нэр	<b>Бүртгэгдээгүй</b>								
Бүртгэгдсэн огноо									
Талбайн хэмжээ (га)	Үндсэн буюу цөм бүс	Орчны бүс	Шилжилтийн бүс	Нийт талбай					
Газарзүйн солбицол									
Дэлхийн Хүн ба Шим мандлын нөөц газрын сүлжээнд бүртгэгдсэн үндэслэл									
Хамгаалалтын зорилгод нийцүүлж хэрэгжүүлсэн ажлууд (3-аас доошгүй үйл ажиллагааны үр дүнг бичих)									
3. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн жагсаалтад бүртгэгдсэн газар - RAMSAR <a href="https://www.ramsar.org/sites-countries/ramsar-sites-around-the-world">https://www.ramsar.org/sites-countries/ramsar-sites-around-the-world</a>									
Газрын нэр	<b>Бүртгэгдээгүй</b>								
Бүртгэгдсэн огноо									
Рамсарын бүртгэлийн дугаар									
Талбайн хэмжээ (га)									
Газарзүйн солбицол									
Рамсарын сүлжээнд бүртгэгдсэн үндэслэл									
Рамсарны шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	C1	C2	C3	C4	C5	C6	C7	C8	C9
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Хамгаалалтын зорилгод нийцүүлж хэрэгжүүлсэн ажлууд (3-аас доошгүй үйл ажиллагааны үр дүнг бичих)									
4. Бусад сүлжээнд бүртгэгдсэн байдал Шувуудад чухал газар, (ИВА), хил дамнансан ТХГН гэх мэт.									
Газрын нэр	<b>Бүртгэгдээгүй</b>								
Бүртгэгдсэн огноо									
Бүртгэлийн дугаар									
Талбайн хэмжээ (га)									
Газарзүйн солбицол									
Хамгаалалтад авсан буюу бүртгэлд хамрагдсан үндэслэл, шалгуур									
Хамгаалалтын зорилгод нийцүүлж хэрэгжүүлсэн ажлууд (3-аас доошгүй үйл ажиллагааны үр дүнг бичих)									

## ДӨРӨВ. ХАМГААЛЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Энэ удаагийн үнэлгээгээр Их газрын чулууны БЦГ-ын менежментийн төлөвлөгөөнд үнэт зүйлээр сонгогдсон зүйл, бүлгэмдлийн үнэт чанар, түүнд учирч буй аюул дарамтыг тодорхойлон гаргалаа. Тус захиргааны 2014-2018 онд хэрэгжүүлсэн менежментийн төлөвлөгөөнд хамгаалах гол үнэт зүйлсийг төлөөлөн Аргаль хонь, янгир ямаа, Байгалийн өвөрмөц тогтоц, түүх соёлын өв, Эмийн болон ховор ургамал, Рашаан булаг гэсэн 4 зүйл сонгосон авсан.

**Үнэт зүйл 1: Аргаль хонь, янгир ямаа:** Аргаль хонь, янгир ямаа болон бусад зэрлэг хөхтөн амьтдын тархац, тоо толгойн байдал нь байгаль цаг уурын таагүй нөхцөл, хүний шууд болон дам нөлөөллөөс тодорхой хэмжээгээр хамаарах тул цаашид нутгийн иргэдэд түшиглэсэн хамгааллыг дэмжих, тэдгээрийг байршин амьдрах нутагт хамгаалах биотехникийн арга хэмжээг шаардлагатай цаг тухайд нь авч хэрэгжүүлэх, өсөж үржих хэвийн нөхцөлийг хангах шаардлага тулгарч байгаа учраас онцлон сонгож авлаа.

**Үнэт зүйл 2: Байгалийн өвөрмөц тогтоц, түүх соёлын өв:** Цогцолборт газарт боржин чулуулгийн өгөршлийн үр дүнд үүссэн байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрууд ихээс гадна булш, хиргисүүр, зэл чулуу зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд цөөнгүй бий. Тухайлбал, Ихийн жасын туурь, Оточ ламын сүмийн туурь, Баянхошууны булш, Хүннү булш, хадны сүг зураг, Баруунсайхан уулын дурсгал зэрэг түүх, соёлын дурсгал, Тоонот, Агуйт, Тангад, Тагтааны бааст, Өлгийн агуй, Эхийн умай агуй зэрэг 40 гаруй агуй, Өвгөн хад, залбирч буй эх, Лянх хад, Сэнжит хад зэрэг өвөрмөц тогтоцтой хад олон бий.

**Үнэт зүйл 3: Эмийн болон ховор ургамал:** Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжилтын судалгаагаар 30 овог, 91 төрөл, 142 зүйл ургамал ургадаг гэсэн дүгнэлт гарсан. Ховор болон эмийн ургамлын байгалийн ач холбогдлыг ойлгодоггүйгээс ахуйн хэрэглээнд хэт ихээр ашиглах явдал зарим зүйлийн ховор болон эмийн ургамал дээр ажиглагдаж байгаа талаар нутгийн иргэд мэдээлж байна.

**Үнэт зүйл 4: Рашаан, булаг:** Их Газрын Чулууны БЦГ-т 9 булаг, 1 рашаан байдаг бөгөөд эдгээрээс одоогийн байдлаар 7 булаг, 1 рашаан ширгэсэн, 2 булгийн ундарга хэвийн байна гэсэн судалгаа гарсан нь тус БЦГ-ын хувьд анхаарал татсан асуудлын нэг юм. БЦГ-ын зүүн урд захад орших Баянбулагийн рашаан нь өвөлдөө харзалдаг.

1-р хүснэгт. Их газрын чулууны БЦГ-ын  
хамгааллын үнэт зүйлсийн өнөөгийн байдал

№	Үнэт зүйл	Муу	Дунд	Сайн	Маш сайн
1	Аргаль хонь, янгир ямаа				4
2	Байгалийн өвөрмөц тогтоц, түүх соёлын өв				4
3	Эмийн болон ховор ургамал			3	
4	Рашаан, булаг			3	

### ТАВ. АЮУЛ, ДАРАМТЫН ҮНЭЛГЭЭ

ТХГН-ийн менежментийн үр ашгийг сайжруулахын тулд тухайн газар нутгийн биологийн олон янз байдалд тулгамдаж буй аюул, дарамтыг тодорхойлж түүнийг бууруулах оновчтой үйл ажиллагааг тодорхойлох шаардлагатай. Их газрын чулууны БЦГ-ын Хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид, аймаг, сумдын ЗДТГ болон иргэдийн оролцоотойгоор Их газрын чулууны БЦГ-ын биологийн олон янз байдалд учирч буй аюул, дарамтыг аргагүйн дагуу аюул, дарамт тус бүрээр; (1) - хамрах хүрээ, (2) - нөлөөллийн хүч, (3) - аюул, дарамтыг бууруулах буюу нөхөн сэргээх боломж гэсэн үндсэн 3 шалгуураар үнэлж, ерөнхий үнэлгээг гаргав.

#### 2-р хүснэгт. Аюул дарамтын төрөл ба үнэлгээ

№	Аюул, дарамтын төрөл	Үнэлгээний шалгуур үзүүлэлт		
		Хамрах хүрээ	Нөлөөллийн зэрэг	Тухайн аюул, дарамтыг бууруулах буюу нөхөн сэргээх боломж
1	Төв суурин газар болон үйлдвэрлэлийн зориулалттай байгууламж – Хүн амын суурьшил болон ХАА-н бус зориулалтаар газар ашиглахтай холбоотойгоор үүсэж буй аюул, дарамт	1	1	1
2	Бэлчээр ашиглалтаас үүдэлтэй аюул, дарамт	3	3	3
3	Ойн нөөцийн ашиглалтаас үүдэлтэй аюул, дарамт	-	-	-
4	Газар тариалангаас үүдэлтэй аюул, дарамт	-	-	-
5	Байгалийн бусад нөөцийн хэт ашиглалтаас үүдэлтэй аюул, дарамт	2	2	2
6	Уул уурхай – Газрын тос, ашигт малтмалын ашиглалтаас үүдэлтэй аюул, дарамт	-	-	-
7	Дэд бүтэц - Зэрлэг амьтны амьдрах орчныг дайран гарсан дэд бүтцээс үүдэлтэй аюул, дарамт	1.5	2	1
8	Харь зүйл болон бусад хөнөөлт зүйлийн тархалтаас үүдэлтэй аюул, дарамт	-	-	-
9	Бохирдол – Хорт болон үлдэгдэл бодисоос үүдэлтэй аюул, дарамт	1	1	1
10	Байгалийн системийн өөрчлөлт – Экосистемийн үйл ажиллагааг алдагдуулж буй бусад үйл ажиллагаанаас үүдэлтэй аюул, дарамт	-	-	-
11	Геологийн үйл явцын нөлөө - Геологийн үйл явц нь байгалийн системийн нэгээхэн хэсэг боловч түүнээс үүдэлтэйгээр учирч буй аюул, дарамт	1	1	1
12	Уур амьсгал, цаг уурын өөрчлөлт – Урт хугацааны туршид цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй аюул, дарамт	2	2	2
13	Өв соёл, нийгмийн өөрчлөлттэй холбоотой аюул, дарамт	-	-	-
	Дундаж	1.6	1.6	1.6
	нийлбэр	11.5	12	11

Аюул дарамт тус бүрийг хамрах хүрээ, нөлөөллийн зэрэг, аюул дарамтыг бууруулах болон доройтсон экосистем, биологийн олон янз байдлыг нөхөн сэргээх боломж гэсэн үндсэн 3 шалгуураар үнэлж, 13 төрлийн аюул, дарамтаас 7 төрлийн аюул, дарамтын дундаж үнэлгээ гарж, 6 төрлийн аюул, дарамт үнэлэгдсэнгүй.

Нийт 7 төрлийн үзүүлэлтийн нийлбэр дүнгээр хамрах хүрээ 11.5, нөлөөллийн зэрэг 12, тухайн аюул, дарамтыг бууруулах буюу доройтсон экосистем, биологийн олон янз байдлыг нөхөн сэргээх боломж 11 гэж гарлаа.

Их газрын чулууны БЦГ-ын үнэт зүйлсэд тулгарч буй аюул дарамтыг үнэлсэн байдлаас багцлан үзэхэд БЦГ дахь бэлчээр ашиглалтаас үүдэлтэй, байгалийн бусад нөөцийн хэт ашиглалт, зэрлэг амьтны амьдрах орчныг дайран гарсан дэд бүтэц, уур амьсгал, цаг уурын өөрчлөлт, төв суурин газар болон үйлдвэрлэлийн зориулалттай байгууламж, геологийн үйл явцын нөлөө, бохирдолоос үүдэлтэй аюул дарамт тэргүүлэх зэргийн нөлөө үзүүлж буйг харж болохоор байна.

## ЗУРГАА. МЕНЕЖМЕНТИЙН ҮР АШИГТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Бид аргазүйд өгөгдсөн нийт 168 онооноос тухайн тусгай хамгаалалттай газарт тохирохгүй 3 асуулгын 9 оноог хасаж нийт үнэлгээг 159 онооноос тооцлоо (Хүснэгт №3). Энэ удаагийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээг 6 үндсэн үзүүлэлтээр ялган авч үзвэл: Хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт 73.3%, Төлөвлөлт, төлөвлөгөө, түүний хэрэгжилт 74.1%, Нөөц боломж 71.8%, Бодит үйл ажиллагаа 80%, Үнэлгээ мониторинг 55.6%, Үр ашиг 66.7 хувиар тус тус үнэлэгдлээ. Үнэлгээгээр авах ёстой нийт 159 онооноос 118 оноо авч менежментийн үр ашигт байдал 70.2 хувьтай (Хавсралт №3) байна. Тус хамгаалалтын захиргаа нь 2018 онд ижил аргазүйгээр хийгдсэн Менежментийн үр ашигт байдлын үнэлгээгээр 60 хувьтай дүгнэгдэж байжээ. Бид эдгээр үзүүлэлт хэрхэн өөрчлөгдснийг тодруулах зорилгоор 2018 онд дүгнэсэн үзүүлэлттэй өөрсдийн үнэлгээг харьцуулан графикт үзүүлэв.


3-р хүснэгт. Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ

№	Үзүүлэлт	Нийт оноо	Авсан Оноо	Хувь
1	Хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт	15	11	73.3
2	Төлөвлөлт, төлөвлөгөө түүний хэрэгжилт	27	20	74.1
3	Хамгаалалтын захиргааны нөөц боломж	39	28	71.8
4	Бодит үйл ажиллагаа	60	48	80.0
5	Үнэлгээ мониторингийн менежментийн үр ашигт байдал	9	5	55.6
6	Экосистем, биологийн олон янз байдлын төлөв байдал болон эдийн засгийн үр ашигт байдал	9	6	66.7
<b>Дундаж үнэлгээ</b>		159	118	70.2

Их газрын чулууны БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээгээр ихэнхи үзүүлэлтүүд ийнхүү 60 хувиас дээш үнэлгээтэй гарсан нь тус БЦГ-ын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа тогтмолжиж, төлөвлөсөн ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд анхаарч ажиллаж байгаагийн нэг гол үр дүн юм.

Үнэлгээний дүнг үндсэн 6 бүлэгт хамаарах шалгуур үзүүлэлтээр ангилан нэгтгэж графикаар үзүүлэв.

1-р график. Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ



## Хүснэгт 7. Менежментийн үр ашигт байдлын үнэлгээний нэгтгэл

Асуулгууд	Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь
<b>НЭГ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ</b>	<b>15</b>	<b>11</b>	<b>73.3%</b>
1.1 Хууль, эрх зүйн статус	3		
1.2 Менежментийг хариуцагчийн эрх зүйн байдал	3		
1.3 Хууль эрх зүйн дэглэм	3		
1.4 Газар, ус ашиглалтыг зохицуулах эрх зүйн орчин	3		
1.5 Хууль эрх зүйн дэглэмийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоо	3		
<b>ХОЁР. ТӨЛӨВЛӨЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ</b>	<b>27</b>	<b>20</b>	<b>74.1%</b>
2.1 ТХГН-ийн зорилго	3		
2.2 ТХГН-ийн төлөвлөлт	3		
2.3 Менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	3		
Нэмэлт үзүүлэлтүүд	3		
2.4 Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт	3		
2.5 Онцгой нөөцийн менежмент*	3		
2.6 Байгаль, түүх, соёлын үнэт зүйлсийн хамгааллын менежмент*	3		
2.7 Олон улсын хамгаалалттай газар нутгийн сүлжээнд бүртгэгдсэн газрын хамгаалалт*	3		
2.8 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох менежмент	3		
2.9 Хүлэмжийн хийг шингээх, нүүрстөрөгчийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн менежмент*	3		
<b>ГУРАВ. НӨӨЦ БОЛОМЖ</b>	<b>39</b>	<b>28</b>	<b>71.8%</b>
3.1 ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, менежментийг хариуцагчийн байгууллагын бүтэц, хүний нөөц	12		
3.1.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт	3		
3.1.2 Мэргэжилтний хангамж, чадавхи	3		
3.1.3 Байгаль хамгаалагчийн хангамж, чадавхи	3		
3.1.4 Ажиллагсдын сургалт	3		
3.2 Ажлын байр, техник тоног төхөөрөмжийн хангамж	12		
3.2.1 Ажлын байрны хангамж	3		
3.2.2 Захиргааны тоног төхөөрөмж	3		
3.2.3 Мэргэжилтэн, байгаль хамгаалагчийн хээрийн ажлын хангалт	3		
3.2.4 Техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засвар үйлчилгээ	3		
3.3 ТХГН-ийн санхүүжилт	15		
3.3.1 Одоогийн төсөв	3		
3.3.2 Төсвийн хуваарилалт, зарцуулалт	3		
3.3.3 Төсвийн тогтвортой байдал	3		
3.3.4 Нөөц ашигласны төлбөр, хураамж	3		
3.3.5 Санхүүжилтийн эх үүсвэр, түүний тогтвортой байдал	3		
<b>ДӨРӨВ. БОДИТ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>60</b>	<b>48</b>	<b>80%</b>
4.1 Хяналт шалгалтын систем	6		
4.1.1 Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалтын хяналт	3		
4.1.2 ТХГН-т нэвтрэх болон хяналтын цэгүүдийн үр нөлөө	3		
4.2 Мэдээлэл харилцаа, сургалт, сурталчилгаа	12		
4.2.1 Байгаль орчны талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөр	3		

Асуулгууд	Авбал зохио оноо	Авсан оноо	Хувь
4.2.2 ТХГН-ийн хил хязгаарын зааг	3		
4.2.3 Мэдээлэл, сурталчилгааны төв, түүний үр нөлөө	3		
4.2.4 ТХГН-ийн сургалтын үр нөлөө	3		
4.3 Судалгаа шинжилгээ, мэдээллийн сан	6		
4.3.1 Мэдээллийн сангийн бүрдэлт	3		
4.3.2 Судалгаа шинжилгээ	3		
4.4 Хамтын менежмент – ТХГН-ийн менежментэд талуудын оролцоо	24		
4.4.1 ТХГН-ийн менежментийг хариуцагч болон орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагаа	3		
4.4.2 Газар, ус ашиглагчдын хамтын ажиллагаа	3		
4.4.3 Нутгийн иргэдийн оролцоо	3		
4.4.4 Нутгийн иргэдийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	3		
Нэмэлт үзүүлэлтүүд	3		
4.4.5 Хил залгаа буюу ойролцоох нутаг дахь ТХГН-ийн хамтын ажиллагаа*	3		
4.4.6 Рамсарт бүртгэгдсэн газарт салбар хоорондын уялдааг хангах менежментийн зөвлөл байгуулагдсан эсэх?*	3		
4.4.7 Рамсарын конвенцийн эрх барих дээд байгуулагатай харилцаа холбоотой эсэх?*	3		
4.5 Аялал жуулчлал	6		
4.5.1 Аялал жуулчлалын дэд бүтэц, аялагчдад зориулсан үйлчилгээ	3		
4.5.2 Аялал жуулчлалд оролцогч талуудын хамтын ажиллагаа	3		
4.6 ТХГН-ийн орчны бүсийн менежмент*	12		
4.6.1 ТХГН-ийн орчны бүсийн чадавхи	3		
4.6.2 Орчны бүсийн зөвлөлийн чадавхи	3		
4.6.3 Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	3		
4.6.4 Орчны бүсийн менежментийн тогтвортой санхүүжилт	3		
<b>ТАВ. ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ</b>	<b>9</b>	<b>5</b>	<b>55.6%</b>
5.1 Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх систем	3		
5.2 Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, уян хатан байдал	3		
Нэмэлт асуултууд	3		
<b>ЗУРГАА. ҮР АШИГ</b>	<b>9</b>	<b>6</b>	<b>66.7%</b>
6.1 ТХГН-ийн үнэт зүйлсийн төлөв байдал	3		
Нэмэлт үзүүлэлтүүд	3		
6.2 ТХГН-ийн эдийн засгийн ач холбогдол	3		
<b>Нийт оноо</b>	<b>159</b>	<b>118</b>	<b>70.2%</b>

**6.1 Хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт:** Их газрын чулууг УИХ-ын 2003 оны 30 дугаар тогтоолоор Байгалийн нөөц газар болгон улсын тусгай хамгаалалтад авсан бөгөөд УИХ-ын 2012 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Байгалийн цогцолборт газар болгон ангиллыг дээшлүүлсэн.

Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А-06 тоот тушаалаар хамгаалалтын захиргааг Дундговь аймгийн Сайнцагаан суманд байгуулсан.

Хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн менежментийн үр ашигт байдал Их газрын чулуу БЦГ-г 73.3 хувьтай үнэлэгдлээ. Цаашид хамгааллын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хүний нөөц, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах хэрэгцээ бий. Хамгаалалтын захиргаа нь одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй ТХГН-ийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хэдийгээр зохих ёсны механизм байгаа боловч байгаль хамгаалагчийн унаа морь, бие хамгаалах хэрэгсэл, байршил тогтоогч зэрэг тоног төхөөрөмж хангалтгүй, байгалийн саад бэрхшээл ихтэй зэрэг нь хяналт, шалгалтыг зохих түвшинд явуулахад хүндрэл учруулж байна

**6.2 Төлөвлөлт, төлөвлөгөө түүний хэрэгжилт:** Төлөвлөлт, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн менежментийн үр ашигт байдал 74.1% -иар үнэлэгдлээ. Их газрын чулууны БЦГ-ын анхны менежментийн төлөвлөгөө (2013-2018)-г 2014 онд боловсруулж мөрдүүлсэн бөгөөд 2018 онд Их газрын чулууны БЦГ-ын менежментийн үр ашигт байдал нь 80.7%-тай үнэлэгдсэн байна. 2021-2025 онд хэрэгжүүлэх хамгийн сүүлчийн менежментийн төлөвлөгөөг 2021 онд хамгаалалтын захиргааны хамт олон өөрсдийн хүчээр боловсруулаад байна.

Олон тусгай хамгаалалттай газрууд хуучин төлөвлөгөө дууссан боловч шинэ төлөвлөгөө хийгдээгүй, эсвэл бэлэн болоогүй байхад тус хамгаалалтын захиргаа нь дараагийн 5 жилийн төлөвлөгөөгөө боловсруулаад батлуулж, хэрэгжүүлж эхлээд байгаа нь сайшаалтай. Гэсэн хэдий боловч шинэчилсэн төлөвлөгөөг мэргэжлийн болон туршлагатай судлаачдаар хянуулах, засаж сайжруулах шаардлага байгааг хамгаалалтын захиргааны зүгээс бидэнд хэлж байлаа.

Менежментийн үйл ажиллагаанд үндэслэн үйл ажиллагааг жилээр нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлдэг. Бүс нутгийн хэмжээнд ховордсон амьтан, ургамлын талаарх мэдээллийг зөвхөн өөрсдийн хүч, нөөц бололцоонд тулгуурлан цуглуулж байна. Цаашид мэргэжлийн судлаачидтай хамтран биологийн төрөл зүйлийн иж бүрэн судалгааг хийж, түүний дагуу хамгааллын арга хэмжээг төлөвлөх шаардлагатай. Нөгөө талаар өөрсдийн болон хамтарсан байдлаар цуглуулсан судалгааны мэдээ, хэрэглэгдэхүүнүүдээ боловсруулж эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, товхимол болгон хэвлүүлэх, олон нийтэд сурталчлан таниулж, шинжлэх ухааны эргэлтэд оруулах ажил орхигдоод байгааг анхаарах шаардлагатай.

**6.3 Нөөц боломж:** Нөөц боломжийн менежментийн үр ашигт байдал 71.8 хувьтай үнэлэгдсэн. Нөөц, боломжийн менежментийн үр ашигт байдлыг төсөв санхүү, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн хангамж гэсэн үндсэн 3 шалгуур үзүүлэлтээр авч үзэхэд, хамгаалалтын захиргааны бүтэц зохион байгуулалт, хүний нөөц 83.3%, ажлын байр, тоног төхөөрөмжийн хангамжийг 75%, санхүүжилтийг 60% байна. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

**Хүний нөөц:** Анх БОНХСайдын 2013 оны 01 сарын 04-ны өдрийн А-06 тушаалаар тус хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоог нийт 10 хүнээр баталж байсан. Мөн БОАЖСайдын 2022 оны 10 сарын 20-ны өдрийн А-439 тушаалаар орон тоог хэвээр хадгалж бүтцийг шинэчлэн баталсан. Үүнээс хамгаалалтын захиргааны дарга 1, Судалгаа шинжилгээ, байгалийн нөөцийн хамгаалалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн 1, Аялал жуулчлал, сургалт, сурталчилгаа, орчны бүс хариуцсан мэргэжилтэн 1, Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн 1, Нягтлан бодогч 1, Архив, бичиг хэрэг, нярав, дотоод ажил хариуцсан ажилтан 1, жолооч 1, үйлчлэгч 1, сахиул 1, байгаль хамгаалагч 4 болно.

Цаашид ХЗ-ний мэргэжилтэн, байгаль хамгаалагчдыг судалгааны аргазүйд сургах, хууль эрхзүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, дэвшилтэт техник тоног төхөөрөмж ашиглалтын чиглэлээр сургах, багаар хамтран ажиллах болон хувь хүний төлөвшил, харилцааны чиглэлээр сургалтыг зохион байгуулах шаардлагатай.

Мөн байгаль хамгаалагчдад тавьдаг дээд сургууль төгссөн байх гэдэг шалгуур нь цаашид хөдөө орон нутагт энэ чиглэлээр ажиллах хүчний хомсдолд оруулж мэдэх эрсдэл дагуулж байгааг уулзалтад оролцогчид сануулж байлаа.

**Ажлын байр, тоног төхөөрөмж:** Хамгаалалтын захиргааны байшин орчин үеийн шаардлагыг хангаж чадахгүй. Аймгийн төвд байрлах боловч нэгдсэн халаалтын системд холбогдоогүй, гадна пасад дутуу тул өвөлдөө хүйтэн байна. Байгаль хамгаалагчийн уналга хэрэгсэл мотоцикл нь байнга эвдэрдэг ба байгаль хамгаалагч нар өөрсдийн зардлаар засварладаг байна. Сүүлийн хэдэн 5 нэг ч удаа харьяа дээд байгууллагаас байгаль хамгаалагчдын унааны асуудлыг шийдвэрлээгүй. Цаашид тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, байгаль хамгаалагчдын хээрийн ажлын хувцсыг шинэчлэх болон иж бүрдэл багажаар хангах, хээрийн судалгааны багаж, хэрэгслээр хангах, хамгаалалтын захиргааны судалгааны багаж хэрэгслийн тоо, төрлийг нэмэгдүүлэх тал дээр анхааран ажиллах шаардлагатай. Тухайлбал байгаль хамгаалагчдын унаанаас гадна хяналт шалгалтын үед хэрэглэх энгэрийн камер, бие хамгаалах хэрэгсэл гэх мэтийг нэн даруй шийдвэрлэх хэрэгтэй. Байгаль хамгаалагчийн уналга хэрэгсэл мотоцикл нь байнга эвдэрдэг ба байгаль хамгаалагч нар өөрсдийн зардлаар засварладаг байна. Цаашид тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, байгаль хамгаалагчдын хээрийн ажлын хувцсыг шинэчлэх болон иж бүрдэл багажаар хангах, хээрийн судалгааны багаж, хэрэгслээр хангах, хамгаалалтын захиргааны судалгааны багаж хэрэгслийн тоо, төрлийг нэмэгдүүлэх тал дээр анхааран ажиллах шаардлагатай.

**Төсөв, санхүү:** Их газрын чулууны БЦГ-т төсөв, санхүүгийн менежментийн үр ашигт байдал дунджаар 56.7 хувьтай үнэлэгдлээ. Сүүлийн 5 жил оноос хойш хамгаалалтын захиргааны төсөв жил бүр тогтмол өссөн байна.

Хамгаалалтын захиргааны 2021 оны төсөв 168,973.3 2022 оных 185,312.7 төгрөг бөгөөд ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд нийт төсвийн 80 хувь нь зарцуулагдаж, үлдсэн 20 хувь нь хяналт шалгалт, сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээ, биотехникийн ажил зэрэг хамгийн чухал ажлуудыг хийж гүйцэтгэхэд хүрэлцдэггүй. Тээвэр, шатахуун, интернэт, шуудан холбооны зардал хүрэлцдэггүй. Ажилчдын нийгмийн асуудалтай холбогдсон зардлууд хасагдсан.

Тус хамгаалалтын захиргааны төсөв сүүлийн 5 жилийн байдлаар жил бүр тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа боловч батлагдсан төсөв бүрэн санхүүжилтээр ирэхгүй байна. 2021 онд 168,9 сая төгрөгний санхүүжилт авснаас 159,4 сая төгрөгийн зардал гарсан байна. Үүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 95,5 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 12,5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,7 сая, хангамж бараа материалын зардал 5,8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,6 сая, харуул хамгаалалтын зардалд 4,4 сая, гэрээт ажиллагсдын зардалд 18,7 сая, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд 7,6 сая, ургамал хамгаалах зардалд 6,7 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна.

Шилэн дансны тухай хууль, шилэн дансанд мэдээлэл оруулах журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өнгөрсөн онд нийт 133 мэдээлэл орохоос хугацаандаа бүрэн орсон мэдээ, хугацаа хоцорсон мэдээ байхгүй

**3.4 Өөрийн орлого:** Хуулийн дагуу ТХГН-ийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн хохирлын нөхөн төлбөр, торгууль шийтгэврийн орлого ордог боловч үйл ажиллагаа, хамгааллын ажилд зарцуулах эрх үүсгэх явц хүндрэлтэй, улсын төсвийн орлого болдог. Одоогоор тусгай хамгаалалтай газарт нэвтэрсний хураамжаар өөрийн орлогоо бүрдүүлж байгаа.

**6.4 Бодит үйл ажиллагаа:** Бодит үйл ажиллагааг хамгаалалтын захиргааны үндсэн үйл ажиллагааг илэрхийлэх эдгээр 6 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд нийт дүнгээр 80% үнэлгээтэй байна. Үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

3-р хүснэгт. Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ

Бодит үйл ажиллагаа	Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь
		60	48
Хяналт шалгалт	6	5	
Мэдээлэл сурталчилгаа сургалт	12	9	
Судалгаа шинжилгээ мэдээллийн сан	6	5	
Талуудын оролцоо	18	15	
Аялал жуулчлал	6	4	
Орчны бүсийн үйл ажиллагаа	12	10	

Их газрын чулууны БЦГ-т 2 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна.



### 6.5 Үнэлгээ, мониторинг

Их газрын чулууны БЦГ-ын үнэлгээ мониторингийн менежментийн үр ашигт байдал 55.6 хувьтай үнэлэгдсэн. Тус БЦГ-т ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ тогтмол хугацаанд хийгддэггүй, талуудын оролцоогүйгээр өөрсдөө үнэлдэг зэрэг дутагдал байна. Менежмент төлөвлөгөөнд тусгагдсан үнэт зүйлийн төлөв байдал, аюул дарамт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт мониторинг хийх ажил тогтмол хийгддэггүй байна. Хамгаалалтын захиргаануудын ажлын төлөвлөгөөг хянаж батлах, үйл ажиллагааны тайлан, үр дүнг бодитой үнэлж дүгнэсэн талаар мэдээлэл хомс байна.

БОАЖЯ-ны ТХБНУГ-аас ТХГН-ийн хамгаалалтын захиргаад талуудын оролцоог хангаж, өөрсдөө менежмент төлөвлөгөөгөө боловсруулж байх бодлого барьж байгаа нь зөв зүйтэй алхам бөгөөд гагцхүү тэдэнд арга зүйн зөвлөгөө өгөх, орчны бүсийн сумдаар явж хэлэлцүүлэг хийх, санал авах, танилцуулахад санхүүгийн дэмжлэг өгөх шаардлагатай юм.

Хамгаалалтын захиргаа менежмент төлөвлөгөөгөө талуудын оролцоотой боловсруулснаар үйл ажиллагаагаа сурталчлан таниулах, нутгийн иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажлын үр дүнг танилцуулах, үнэлгээ хяналт мониторингийг хийхэд чухал ач холбогдолтой юм. Цаашид үр менежментийн ашигт байдлыг дээшлүүлэхийн тулд төлөвлөлтийг оновчтой болгох, менежмент төлөвлөгөөний үр дүн, жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол үнэлгээ мониторинг хийж, үр дүн, анхаарах асуудлыг хамгаалал менежментийн ажилдаа тусгаж ажиллах нь зүйтэй.

### 6.6 Үр ашиг

Их газрын чулууны БЦГ-ын Үр ашгийн менежментийн үнэлгээ нь 66.7 хувийн үнэлгээтэй гарсан. Хамгаалалттай газрын дундуур нүүрс тээврийн улсын чанартай авто зам явдаг нь ихээхэн эрсдэл дагуулж байна. Үүнээс гадна зарим тохиолдолд зөвшөөрөгдөөгүй зам, газраар том тэрэг зорчих зөрчил гардаг. Үүнд байгаль хамгаалагч нар, нутгийн иргэдтэй хамтран ажиллаж зөрчил, дутагдлыг газар дээр нь засаж залруулах, зохих арга хэмжээг авч ажиллаж байна. Хэдийгээр энэ мэт зөрчил байдаг хэдий ч хамгаалалтын үнэт зүйлсийн төлөв байдалд хэвийн байгаа нь сайн.

Орчны болон хязгаарлалтын бүсэд байгаа иргэд, нөхөрлөлүүд аялал жуулчлалын үйл ажиллагаанаас маш бага хэмжээний орлого олдог ба тус хамгаалалттай газрын экологи, эдийн засгийн үнэлгээг нарийвчлан хийгээгүй, энэ талаар мэдээлэл хомс байна. БЦГ-ын экосистемийг бүхэлд нь хамгаалж, байгалийн тэнцвэрт байдлыг хангах, экосистемийн олон төрлийн үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр нутгийн иргэд, аялагч жуулчдад шууд болон дам байдлаар чухал нөлөө үзүүлж байна. Орчны бүс нутгийн иргэдийг мэдээллээр хангах, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Цаашид хамгаалалттай газар нутгийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарал тавьж ажиллах шаардлагатай. Орчны бүсийн иргэдийн амьдрал ахуйг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, орлогын эх үүсвэрийг солонгоруулж, аялал жуулчлалаас ашиг хүртэх бололцоог хангах тал дээр хамгаалалтын захиргаа орон нутагтай хамтран тэргүүлэх үүрэгтэй оролцвол зохино.

## ДҮГНЭЛТ

1. Их газрын нурууны БЦГ-ын МҮАБҮ 70.2 хувьтай гарлаа.
2. Бодит үйл ажиллагаа сайн боловч үнэлгээ мониторинг болон үр ашигт байдал гэсэн хэсгүүд хамгийн хангалтгүй үнэлэгджээ. .
3. Хууль эрх зүйн зохицуулалт болон төлөвлөлт, түүний хэрэгжилт хамгийн хангалтгүй байдлаар дүгнэгдэв.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Байгаль хамгаалагчийн орон тоог нэмэгдүүлэх, байгаль хамгаалагчдыг Төрийн албан хаагчийн шалгалтанд тэнцүүлж БОХУБайцаагийн эрхийг олгуулах.
- Харуул хамгаалалт хяналт шалгалтын зардлыг нэмэгдүүлэх.
- Уур амьсгалийн өөрчлөлтийн мониторинг судалгааг хийх
- Шаардлагтай сургалтуудыг төлөвлөх
- Мэргэжил дээшлүүлэх сургалт авах шаардлагатай
- Үе шаттай сургалтуудыг төлөвлөж мэргэжилтэн байгаль хамгаалагчдыг чадавхжуулах шаардлагатай.
- Хамгаалалтын захиргааны байрыг шинээр барьж ашиглалтанд оруулах
- Газар зүйн онцлогт тохирсон эдэлгээ даах чадвартай чанартай мотоцикль, бартаат зам туулах чадвар бүхийн автомашинтай болох.
- Бүх байгаль хамгаалагчдыг судалгааны багаж хэрэгслэл дээр ажиллаж сургах түүнтэй харьцах арга зүйн сургалтыг зохион байгуулах.
- Мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож цогцолборт газрын хэмжээнд бие даасан судалгааны ажлуудыг эхлүүлэх шаардлагатай
- Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад шаардагдах төсвийг хийж аймаг орон нутагт уламжилж 2-3 сумын ОБ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай.
- Биосан програмд мэдээллийг дэлгэрэнгүй оруулж байх
- үнэт зүйлсийн хамгаалал, хэмжих боломжит нөхцөлд тулгуурласан судалгаа, хамгааллын ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. 2021. Хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний арга
2. Монгол улсын УИХ. 1994. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
3. Их газрын чулууны БЦГ - ын менежментийн төлөвлөгөө (2014-2018)
4. Их газрын чулууны БЦГ - ын менежментийн төлөвлөгөө (2022–2026)
5. Их газрын чулууны БЦГ-ын менежментийн үр ашигт байдлын үнэлгээний дүн 2018 он
6. Их газрын чулууны БЦГ – ын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн ажлын тайлан
7. Их газрын чулууны БЦГ – ын хамгаалалтын захиргааны 2016-2021 оны жилийн эцсийн ажлын тайлан
8. Их газрын чулууны БЦГ – ын хамгаалалтын захиргааны 2022 оны эхний хагас жилийн ажлын тайлан
9. Их газрын чулууны БЦГ – ын хамгаалалтын захиргааны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
10. Их газрын чулууны БЦГ – ын хамгаалалтын захиргааны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
11. Намхай А.2022., Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд.